

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ЯВЦАД 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2017 оны 6 дугаар сарын 28

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2017 оны эхний хагас жилийн тайлан, Ашигт малтмал, газрын тосны газраас гаргадаг статистик мэдээллийн эмхтгэл болон бодлогын газруудын үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн онд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг мөн оны хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 36 зорилтын 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг толгойлон, 28 арга хэмжээг хамтран, 1 арга хэмжээг оролцогчоор хэрэгжүүлэхээр тусгагдсаныг хяналтанд авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эхний хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим системд байршуулсан 28 зорилтын 85 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Биелэлт гаргаж үнэлгээ хийсэн 85 арга хэмжээнээс 65 арга хэмжээг яам толгойлон, 20 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлжээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээний 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 50.0 хувь, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээний 22 зорилтын 73 арга хэмжээний биелэлт 58,3 хувь, Нийгмийн бодлогын

хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 4 зорилтын 8 арга хэмжээний биелэлт 40,0 хувь, эхний хагас жилд хэрэгжүүлсэн нийт 85 арга хэмжээний биелэлтийг 57,5 хувьтай дүгнэлээ.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

/2017 оны хагас жил/

/Зорилт, арга хэмжээгээр/

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
			100	70	40	0	/-/	
Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	1	3		1	2			50,0
Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	22	73	9	20	34		10	58,28
Гурав. Нийгмийн бодлого	1	1					1	/-/
Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	4	8			2		6	40,0
<b>Дүн</b>	<b>28</b>	<b>85</b>	<b>9</b>	<b>21</b>	<b>38</b>		<b>17</b>	<b>57,46</b>

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хэрэгжүүлэх он тус бүрээр үзүүлэв.

Хэрэгжүүлэх он	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн дундаж, %
2017	12	66,6
2016-2017	16	64,2
2016-2018	2	40,0
2016-2019	5	40,0
2016-2020	29	54,3
2017-2018	7	52,8
2017-2020	14	33,0

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан дараах арга хэмжээний биелэлтэд 100 хувийн үнэлгээг өгөв. Үүнд:

- 2.64.1. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн боловсруулах,
- 2.67.1. Тухайн үйлдвэрийн технологиор ашиглах боломжгүй овоолго, хаягдлын аж ахуйг эргүүлэн ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- 2.69.1. "Алт-2" хөтөлбөрийг боловсруулан батлуулах,
- 2.70.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх,
- 2.70.2. Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах,
- 2.72.2. Давах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэх цехийг ашиглалтад оруулах,
- 2.73.1. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн нэгж байгуулах,

- 2.73.2. Дэлхийн банкны санхүүжилтээр боловсруулагдсан нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг хүлээж авах,
- 2.73.3. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ болон БОННУ-г Хүнд үйлдвэрийн шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх.

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас хамтран ажиллах санал ирүүлээгүй, яамны зүгээс тодорхой хийгдсэн ажлын биелэлтгүй 11 арга хэмжээ байна. Яам толгойлон хэрэгжүүлэх 6 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй тул үнэлгээ өгөөгүй болно. Үүнд:

- 2.65.2. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах,
- 2.66.1. Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах,
- 2.66.2. Уул уурхайн судалгааны нэгж байгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх,
- 2.70.4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах,
- 2.71.2. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлыг хийх,
- 2.71.3. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах,

#### **Дөрөв. Дүгнэлт.**

Яам толгойлон 2016-2017 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 14 арга хэмжээ, үүний дотор “Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого”-ыг шинэчлэн боловсруулах, цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлыг хийх ажлууд хоцролттой байна.

Мөн 2017 онд хэрэгжүүлэх 11 арга хэмжээ, үүнээс яам толгойлон хэрэгжүүлэх Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж, хэрэгжүүлэх, уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах, холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх зэрэг ажлуудыг ондоо багтаан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй бэрхшээл давтагдаж байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2017 оны хагас жилийн байдлаар 57,4 хувьтай үнэллээ. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 9 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 21 арга хэмжээ 70 хувь, 38 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй байна.

### **Тав. Зөвлөмж.**

Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй, яамнаас биелэлт гардаггүй бэрхшээл үүсч байгааг анхаарч яамны зүгээс эдгээр байгууллагатай хамтран ажиллах талаар идэвх санаачлага гаргаж ажиллах нь зүйтэй.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг тухайн жилд хүрэх түвшин, зарцуулсан хөрөнгийн хэмжээг төлөвлөгдсөн дүнтэй нь харьцуулан гаргаж байхад бодлогын газрууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан нэгтгэлийг хавсаргав.

2017/06/28